



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн талбайн хэлбэр
(солбицол) өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн талбайн хэлбэр (солбицол) өөрчилж байгаа хавсралтад дурдсан нэр бүхий 12 (арван хоёр) иргэний эзэмшил газрын талбайн хэлбэр(солбицол)-д өөрчлөлт оруулж хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2012 оны А/176 дугаар захирамжийн Сүхбаатар Саранчимэг, 2014 оны 466 дугаар захирамжийн Содномцэрэн Болормаа, 2012 оны 77 дугаар захирамжийн Бямбаа Ариунбат, 2024 оны А/254 дүгээр захирамжийн Бат-Эрдэнэ Батзолбоо, 2016 оны А/740 дүгээр захирамжийн Цэвээнравдан Насанбат, 2023 оны А/394 дүгээр захирамжийн Пүрвээ Дамбасүрэн, Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албаны даргын 2024 оны А/48 дугаар тушаалын Анхбаатар Дөлгөөн, 2024 оны А/42 дугаар тушаалын Нэрхүү Батрагчаа, 2024 оны А/26 дугаар тушаалын Отгонбаяр Оюунсүрэн, 2024 оны А/28 дугаар тушаалын Хайдав Мөнхсолонго, 2024 оны А/28 дугаар тушаалын Хайдав Мөнхцацрал, 2024 оны А/40 дүгээр тушаалын Зундуй Оюунбилэг нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмших эрхийн талбайн хэлбэр(солбицол) өөрчлөгдсөн иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010273